


Нийслэлийн нийтлэг үйлчилгээний
газрын даргын 2020 оны 95 дугаар
сарын 19-ний өдрийн 96 дугаар
тушаалын гуравдугаар хавсралт



БАЙГУУЛЛАГЫН “ШИЛДЭГ АЖИЛТАН” ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь тухайн онд Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын дүрмээр хүлээсэн үүргийг хэрэгжүүлэхэд ур чадвар, манлайллаараа хамт олноо тэргүүлэн ажилласан ажилтан, албан хаагчийг шалгаруулан, хөдөлмөр зүтгэлийг нь урамшуулан дэмжихэд оршино.

1.2. “Шилдэг ажилтан” шалгаруулахдаа шударга, ил тод зарчмыг баримтална.

1.3. “Шилдэг ажилтан”-ыг нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарын болон байгууллагын ойн баяраар тус тус шалгаруулна.

Хоёр. Шалгуур үзүүлэлт

2.1. Хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны тодорхойлолтод заагдсан ажил үүргийн хэрэгжилтийг ханган ажиллахад идэвх санаачилга гарган, бусдыгаа манлайлан үр бүтээлтэй, санал санаачилгатай ажилласан байх;

2.2 Хөдөлмөрийн дотоод журам холбогдох бусад эрх зүйн актуудыг мөрдөж, хэрэгжүүлэн ажиллаж, сахилгын болон ёс зүйн зөрчил гаргаагүй байх;

2.3 Ажлын цаг ашиглалт сайн байх;

2.4 Байгууллагаас зохион байгуулж байгаа цаг үеийн ажилд тогтмол идэвх, санаачлагатай оролцсон байх;

Гурав. Шилдэг ажилтан шалгаруулах, урамшуулал

3.1. Шилдэг ажилтанд нэрийг нь дэвшүүлэх ажилтан, албан хаагчид холбогдох дараах баримт бичгийг тогтоосон хугацаанд Захиргаа, санхүүгийн хэлтэст ирүүлнэ.

3.1.1. хамт олны хурлаар шалгаруулсан тухай хурлын тэмдэглэл;

3.1.2. тайлант хугацааны гүйцэтгэсэн ажлын тайлан;

3.1.3. хөдөлмөрийн сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй тухай хүний нөөцийн менежер, ёс зүйн зөвлөлийн тодорхойлолт;

3.1.4. ажлын цаг ашиглалт шаардлагыг хангасан тухай дотоод хяналт хариуцсан ажилтын тодорхойлолт;

3.2 Дээрхи баримт бичгийг үндэслэн даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцэж, ажилтан, албан хаагчийг шалгаруулна.

3.3. “Шилдэг ажилтан”-аар шалгарсан ажилтан, албан хаагчийг “Өргөмжлөл” мөнгөн шагналаар шагнаж урамшуулна.